

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2009 оны 10 дугаар
сарын 10-ны өдөр

Дугаар 199

Улаанбаатар хот

Г Мэдээллийн технологийн хэлтэс байгуулж, Г
тогтоолын зарим заалтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 18.1, Монгол Улсын Их Хурлын 2006 оны 45 дугаар тогтоолоор батлагдсан “Санхүүгийн зохицуулах хорооны дүрэм”-ийн 4.4 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын албаны орон тоонд багтаан түүний бүтцэд Мэдээллийн технологийн хэлтэс байгуулсугай.

2. Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны “Хорооны Ажлын албаны бүтэц, тэдгээрийн чиг үүрэг батлах тухай” 46 дугаар тогтоолын Нэг дэх хэсэгт дор дурдсан агуулгатай 9, 10 дахь заалт нэмсүгэй:

“9. Мэдээллийн технологийн хэлтэс

10. Санхүүгийн тасаг”

3. Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 46 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын албаны бүтцийн нэгжүүдийн үйл ажиллагааны чиг үүрэг”-т дор дурдсан агуулгатай Арваннэг, Арванхоёр дахь хэсэг, 5.24 дэх заалт тус тус нэмсүгэй:

1/ “**Арван нэг. Мэдээллийн технологийн хэлтэс**

Хорооны зохицуулалтын үйл ажиллагааны хүрээнд мэдээлэл, харилцаа холбоо, технологийн бодлого, чиглэлийг боловсруулах, дэвшилтэт технологи нэвтрүүлэх, найдвартай ажиллагааг хангах, Олон Улсын туршлага, стандартыг судалж санхүүгийн системийн мэдээллийн технологийг сайжруулахад чиглэсэн заавар, зөвлөгөө боловсруулах, сургалт явуулах, санхүүгийн салбарын хэрэглэгч, оролцогчдын эрх ашгийг хамгаалах дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

11.1. Санхүүгийн салбарын мэдээлэл, технологийн чиглэл, хэтийн төлөвлөгөө, зөвлөмж, стандарт, холбогдох журмуудыг боловсруулах, хэрэгжүүлэх,

11.2. Хороо, Ажлын албанд ашиглагдаж буй дотоод мэдээллийн сүлжээний найдвартай ажиллагаа, мэдээллийн бүрэн бүтэн байдал, хадгалалт, хамгаалалт, нууцлалыг хариуцах,

11.3. Хорооны зохицуулалтын үйлчилгээний хүрээнд мэдээллийн нэгдсэн сан, сүлжээ байгуулах, түүний нууцлал аюулгүй байдлыг хангах, программ хангамжийн хэвийн ажиллагааг хангах, хөгжүүлж сайжруулах,

11.4. Хорооны хэрэгцээнд програм хангамж боловсруулах, шинэ технологи судлах, нэвтрүүлэх,

11.5. Хорооны газар, хэлтсүүдийн санхүүгийн мэдээлэл, нэгтгэл хариуцсан ажилтнуудыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, нийт ажилтнуудад мэдээлэл, технологийн чиглэлийн сургалтыг төлөвлөгөөтэй зохион байгуулах,

11.6. Хорооны компьютерийн холбогдох техник хангамжийн захиалга, суурилуулалт, туршилт, тэдгээрийн найдвартай ажиллагаа, засвар үйлчилгээг хариуцан ажиллах,

11.7. Хорооны Вэб хуудасны хэвийн, найдвартай ажиллагааг хангаж ажиллах, цаашид хөгжүүлж, сайжруулах, Хорооны Ажлын албанаас ирүүлсэн баримтын дагуу Вэб талбарт нэмэлт мэдээлэл байршуулах эсхүл хасах ажлыг тухай бүр шуурхай гүйцэтгэх,

11.8. Дотоодын болон гадаадын байгууллагаас Хорооны дэргэд хэрэгжих мэдээлэл, харилцаа холбоо, технологийн чиглэлийн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийг хариуцан хяналт тавьж ажиллах,

11.9. Санхүүгийн салбарын хэрэглэгч, оролцогчдын хууль ёсны эрх ашгийг, болзошгүй эрсдэлээс хамгаалах, Хорооны хүлээх чиг үүргийн дагуу санхүүгийн зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагуудын үйл ажиллагаанд ашиглах программ хангамжид хяналт тавьж, үзлэг хийх, мэргэжлийн дүгнэлт, тайлан, акт гаргах, зөвлөгөө өгөх.”

2/ **“Арванхоёр. Санхүүгийн тасаг”**

3/ “5.24. Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай Монгол Улсын хуулийн хэрэгжилтэд хяналт тавих.”

4. Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 46 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын албаны бүтцийн нэгжүүдийн үйл ажиллагааны чиг үүрэг”-ийн 6.19 дэх заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/ “6.13 Тогтоосон журмын дагуу Хорооны Вэб хуудасны шинэчлэгдэх агуулга бүхий мэдээллийг Вэб талбарт байршуулах эсхүл хасуулахаар тухай бүр Мэдээллийн технологийн хэлтэст шилжүүлэх,”

5. Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 46 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын албаны бүтцийн нэгжүүдийн үйл ажиллагааны чиг үүрэг”-ийн 6.12 – 6.17, 6.24 дэх заалтуудыг 12.1 – 12.6, 6.21-6.23 гэснийг 6.14-6.16 гэж шинэчлэн дугаарласугай.

6. Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 46 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын албаны бүтцийн нэгжүүдийн үйл ажиллагааны чиг үүрэг”-ийн 6.18, 6.20 дахь заалтуудыг хүчингүй болсонд тооцож, 2009 оны 155 дугаар тогтоолын 1 дэх заалтаас “...бүтцийн схем” гэснийг хассугай.

7. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газар /Н.Удаанжаргал/-т даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

Хуулбар үнэн:
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

О.ГАНБАТ